



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/252

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, сэргээх,
хэсэгчлэн хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.20.5, 19.22, 19.23 Эрүүл мэндийн яамны "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, эрх сэргээх байгууллагын нэрсийг хоёрдугаар, хэсэгчлэн хүчингүй болгох байгууллагын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081063

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 06 сарын 26 өдрийн
А/252 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР БОЛОН НЭМЭЛТЭЭР ОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Монос фарм ХХК	сэтгэцэт нөлөөт эм үйлдвэрлэх	3 жил
2	Монос фарм ХХК	эмийн түүхий эд импортлох ханган нийлүүлэх	3 жил
3	Фоба ХХК	эмнэлгийн хэрэгсэл, урвалж портез, эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох ханган нийлүүлэх	3 жил
4	Мон шинжүкү скин мед ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох ханган нийлүүлэх	3 жил
5	Кайзер ХХК	биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох ханган нийлүүлэх	3 жил
6	Эн жи юнайтед ХХК	эм импортлох ханган нийлүүлэх	3 жил
7	Монгол кон ван вон ХХК	биологийн идэвхит бүтээгдэхүүн үйлдвэрлэх	3 жил
8	Нью фаберлик ХХК	эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох	3 жил
9	Окси мед ХХК	эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох	3 жил
10	Аргалант ХХК	биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох ханган нийлүүлэх	3 жил
11	Долоон Одой медикал ХХК	Сэргээн засах төв	3 жил
12	Реженератив медикал центр ХХК	Тусгай мэргэжлийн төв/ Нөхөн үржихүй, үргүйдэл/	3 жил
13	Интернейшнл медикал центр ХХК	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг/Хэвлийн хөндийн мэс	3 жил


Эрүүл мэндийн сайдын
2018 оны 06 сарын 06 өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СЭРГЭЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Нандин фарм трейд ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх
2.	Повернутрэшн ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 06 сарын 06 өдрийн
А/252 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХЭСЭГЧЛЭН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Апрель ХХК	Эрүү нүүр, арьс гоо засал, дотор, сэргээн засах тусламж үйлчилгээ